



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 7610

Булган сум

### Нийлүүлэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Нэгдсэн эмнэлгийн аюултай хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэх автоклав нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан “Мед буян” ХХК-тай 74,800,000 (далан дөрвөн сая найман зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Мягмар)-д олгосугай.

2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Мягмар)-д үүрэг болгосугай.


3. Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, техникийн үзүүлэлтийн дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Мед буян” ХХК-ийн захирал (Н.Буянбадрах)-д даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус төсөл арга хэмжээний санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Дос/2024/Захирамж

6324010287

Аймгийн Засаг даргын 2024 оны  
04 дүгээр сарын 04 ний өдрийн 12 дугаар  
захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Тайлбар	Хариуцах албан тушаалтан
1	Бараа нийлүүлсний дараах чанарын болон баталгаат засварын хугацаа	2 жил	М.Мягмар
2	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
3	Бараа нийлүүлэх хугацаа	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 45 хоног	М.Мягмар